

# МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Код 13.060.70

<b>Усны чанар. Шимэгч хорхой илрүүлэх арга Water quality. Method of helminthological analysis</b>	<b>MNS 5033 : 2001</b>
---	------------------------

Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төвийн зөвлөлийн 2001 оны 04-р сарын 26-ний өдрийн 21 дугаар тогтоолоор батлав.

2001 оны 05-р сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

## 1. Хамрах ба хэрэглэх хүрээ

Энэ стандартыг усанд шимэгч хорхойн өндөг илрүүлж, тодорхойлоход хамаарна.

### 1. Норматив ишлэл

Дор дурдсан стандартууд нь энэхүү стандартын бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ стандартыг нийтлэн гаргах үед эдгээр стандартууд нь хүчин төгөлдөр байсан бөгөөд бүх стандартуудыг дахин хянаж, сайжруулдаг.

MNS ISO 78-2 : 2000      Стандартын бичлэг. 2-р хэсэг. Химийн шинжилгээний арга

MNS 1-3 : 2001          Монгол улсын стандартчиллын тогтолцоо. 3-р хэсэг: Стандартын бүтэц, бичлэг

### 3. Аргын үндэслэл

Тунадасжих урвалын тусламжтайгаар усанд шимэгч хорхойн өндгийг илрүүлж тодорхойлно.

### 4. Урвалж бодис ба материал

“Шинжилгээнд зориулсан цэвэр” ангиллын урвалж, хоёр дахин нэрсэн ус хэрэглэнэ.

4.1. 6 номерийн шүүлтүүр

4.2. Шүүгч цаас

4.3. Тавиур шил

4.4. Бүрхүүл шил

4.5. Дусаагуур

4.6. Хурилдуур

4.7. Хуруу шил

4.8. Люголын уусмал 25%

## **MNS 5033 :2001**

- 4.9. Глицерин 50 %
- 4.10. Давсны хүчил 3%
- 4.11. Азот хүчлийн натрийн ханасан уусмал

## **5. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**

- 5.1. Электрон жин, 0.0001г нарийвчлалтай.
- 5.2. Гольдманы аппарат
- 5.3. Микроскоп

## **6. Дээжлэлт ба дээж**

Худаг буюу усан сангаас усыг авахдаа дээж авах хувин савыг 3-5 удаа зайлсны дараа авна.

Урсгал уснаас дээжийг авахдаа усыг бохирдуулж болох цэгийн дээд доод урсгалын эрэг орчмоос ба эргээс 10-15 м зайнаас усны гадаргуугаас ба гүнээс авна. Дээж авахдаа 5 мин тутам 0.5 литр ус хуримтлагдаж байхаар бодож 1 цагийн турш авна.

Ил задгай ба тогтонги уснаас авсан дээжин дээрээ 0.4-0.6 гр / литрээр бодож хүхэр хүчлийн хөнгөн цагаан нэмж сайтар сэгсрэхэд хөвөн байдалтай тунадас үүснэ.

Үүссэн тунадастай хамт хорхойн өндөг савны ёроолд үлдэнэ. Ус тунадасжих явц 40-50 минутын турш үргэлжилнэ. Тунадасжсан усны дээд хэсгийг асгаад тундасыг саванд хийж лабораторит хүргэнэ.

## **7. Шинжилгээний аргачлал**

- 7.1. Ундны цэвэр усыг Гольдманы аппаратанд 6 номерийн шүүлтүүрээр шүүнэ. 1 цагт 10 л ундны усыг шүүхдээ шүүлтүүрийг 15 дахин, бохирусыг шүүхдээ 30-40 дахин солино. Ус шүүсэн шүүлтүүрийг нойтон байхад нь тавиур шилэн дээр тавьж бичил харуурын бага өсгөгчөөр харна.

Гольдманы аппарат байхгүй нөхцөлд шүүдэг цаасаар шүүнэ. Ийм аргаар шүүсэн үед ус шүүсэн шүүдэг цаасыг нойтноор жижиглэн хэрчиж түүн дээрээ 50% глицерин 1-2 дуслыг дусааж бичил харуурт харна.

Шүүлтүүр дээр шүүгдсэн тунадас нь хэт зузаан байвал бүрхүүл шилээр нимгэлэн авч тавиур шилэн дээр түрхээд дээр нь 50%-ийн глицерин дусааж бичил харуурт харна. Усыг дөнгөж шүүсний дараа шүүлтүүрийг бичил харуурт харах боломжгүй бол түүнийг тасалгааны хэмд хатааж хөргөгчинд хадгалаад, харах үедээ глицерин дусааж зөөлөрсний дараа харна.

- 7.2. Тогтонги усыг химийн бодисын тусламжтайгаар тунадасжуулснаас үүссэн тундасыг хурилдуурт 3-5 минутын турш эргүүлээд дээд талын шингэнийг

асгаж, үлдсэн тунадас дээр нь 3%-ийн 3 мл давсны хүчлийн уусмал нэмж тундасыг уусгаад 3-5 минут холимогийг хурилдуурт дахин эргүүлнэ.

Дараа нь хуруу шилтэй шингэнийг тэгш сууринд сууурилуулж бялхан дүүртэл азот хүчлийн натрийн ханасан уусмал нэмж тавиур шилээр таглан 25-30 минут болсны дараа тавиур шилийг болгоомжтой эргүүлэн авч бичил харуурт шинжилнэ.

## **8 Үр дүнг илэрхийлэх**

Бичил харуурт харж шимэгч хорхойн өндөг байгаа эсэхийг тогтооно.

Өндөг илэрсэн тохиолдолд” Шимэгч хорхойн өндгийг таних бичиг“-ийн тусламжтайгаар тодорхойлно.

**Хавсралт А  
(Мэдээлэл)**

---

Ном зүй

- 1 Шимэгч хорхойн өндгийг таних бичиг

**ТӨГСӨВ.**